



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2024. 09. 03

№

744

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ  
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Б.УРАНЧИМЭГ ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн  
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Батсүхийн Уранчимэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

2327-3870

## Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Батсүхийн Уранчимэг /РД: СУ71032464/-ийн Цэнхэрмандал сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Б.Уранчимэгийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Цэнхэрмандал сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР



Д.ОЮУНТУЯА


БОЛОВСРУУЛСАН:  
АУДИТОР



Т.АЛТАНШАГАЙ

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД



ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН 2024 ОНЫ  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
БАТСҮХ ОВОГТОЙ УРАНЧИМЭГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Б.Уранчимэг миний бие 2024 оны орон нутгийн сонгуульд бие даан дараах 5 бүлэг 15 зүйлийн мөрийн хөтөлбөртэй оролцож байна.

**1. Сумын хөгжлийн төлөвлөгөө төсөл хөтөлбөрийн хүрээнд**

- 1.1 Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх
- 1.2 Төсөл хөтөлбөрийн шалгаруулалтыг ил тод нээлттэй болгох
- 1.3 Суманд төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлуудад хяналт тавин ажиллах

**2. Боловсролын чиглэлээр**

- 2.1 Сумын Ерөнхий боловсролын сургууль төгссөн суралцагчдыг тухайн орон нутагт хэрэгцээтэй мэргэжлээр дэвшин суралцахад чиглэсэн төсөл хөтөлбөрт хамруулах
- 2.2 Тухайн орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж төгссөн мэргэжилтэнг орон нутагт ажиллах нөхцөл бололцоог хангах тал дээр сумын Засаг захиргаатай хамтран ажиллах
- 2.3 Сургуулийн өмнөх боловсролыг дэмжин гэр цэцэрлэгийг баг болгонд ажиллуулах

**3. Иргэдийн эрүүл мэндийн чиглэлээр**

- 3.1 Алслагдсан багийн өндөр настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг улиралд нэг удаа эмчийн үзлэгт хамруулах тал дээр эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах
- 3.2 Өндөр настан, зорилтод бүлгийн иргэдийг хөнгөлттэй нөхцөлттэйгээр рашаан сувилалд хамруулах боломжийг судлан хэрэгжүүлэн ажиллах
- 3.3 Эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлж буй эмийн хөнгөлөлтөнд иргэдийг хамруулах тал дээр суманд үйл ажиллагаа явуулж буй эмийн сантай хамтран ажиллах

**4. Байгаль орчны чиглэлээр**

- 4.1 Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах худаг ус нэмэгдүүлэх тал дээр боломж бололцоог судлан хэрэгжүүлэн ажиллах
- 4.2 Байгаль орчныг хамгаалах голын ай сав дагуу хаясан хог хаягдлыг ачиж цэвэрлэх тал дээр багийн засаг дарга болон малчидтай хамтран ажиллах
- 4.3 Малчдын хашаа хороог засаж сэлбэх, малчдыг хашаажуулах мод түлээ бэлтгэх талаар сумын мод бэлтгэх ангиудтай хамтран ажиллах

2317144237  
046-777-999  



## 5. Мал эмнэлэгийн чиглэлээр

5.1 Малын эрүүл мэндийг хамгаалах халдварт, шимэгчлэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын үүлдэр угсааг сайжруулах тал дээр малчидтай хамтран ажиллах

5.2 Хавар, намрын мал угаалга, тарилга туулгалтанд малыг бүрэн хамруулах тал дээр анхааран ажиллах

5.3 Мал эмнэлгийг бэхжүүлэх, боловсон хүчнийг нэмэгдүүлэх, малын эмчийн ажиллах нөхцөл бололцоог хангах тал дээр сум орон нутгийн удирдлагуудтай хамтран ажиллана

Цаашид иргэдийг мэдээллээр хангаж төр-иргэний гүүр болж ажиллахаар Иргэдийн төлөөлөгчдийн хуралд бие даан нэр дэвшиж байна.



A handwritten signature in Mongolian script is located at the bottom right of the page. The signature is fluid and cursive, consisting of several connected strokes.